



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

**УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ПРОТОКОЛ**



ТУУТ (TSM) СТАНДАРТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ПРОТОКОЛ

УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Зорилго

Энэхүү үнэлгээний протоколын гол зорилго нь Тогтвортой уул уурхайн төлөө (цаашид ТУУТ гэж явах) стандартын үзүүлэлтүүдийн дагуу усны менежментийн гүйцэтгэлийн үнэлгээг хийлгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Үнэлгээний протокол нь ТУУТ стандартын хүрээнд уул уурхайн компаниудад тавигдах усны менежментийн ерөнхий хүлээлтийг тодорхойлсон бөгөөд усны менежментийн хүрээний зорилгыг хэрэгжүүлэхэд түлхэц болдог.

ТУУТ стандартын хувьд бусад менежментийн системд хийгддэг ямар ч үнэлгээний нэгэн адил үзүүлэлт, хамаарах шалгуур нэг бүрийг хангасан эсэх, менежментийн үйл явцын чанар, үйл ажиллагаанд мэргэжлийн дүн шинжилгээ, дүгнэлт хийхийг шаардана. Тиймээс тус протоколыг ашиглахад аудит, системийн үнэлгээний чиглэлээрх мэдлэг, чадвар, мөн усны менежментийн практик мэдлэг, туршлага, үүнд хамаарах зохицуулалтууд, тавигдаж буй шаардлагуудын талаарх мэдлэг, туршлагатай байхыг шаардана. Харин протокол нь дангаараа усны менежментийн гүйцэтгэлийн үр дүнтэй байдлыг баталгаажуулахгүй.

Ус ашиглалтын менежмент нь хаягдлын менежменттэй хамааралтай бол энэхүү протоколыг хэрэглэгчид нь тус протокол болон Хаягдлын менежментийн протокол хооронд боломжит уялдаа холбоо буй болохыг мэдэж байх нь чухал.

ТУУТ стандартын удирдамж зарчмуудын хүрээнд Канадын Уул уурхайн ассоциацийн гишүүн байгууллагууд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Энэхүү протокол нь усны менежментийн чиглэлээрх үйл ажиллагааг хуульд нийцүүлэхээс гадна илүү өндөр түвшинд хэрэгжүүлэхэд чиглэл өгөх зорилготой.

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Энэхүү зорилгод хүрэх гүйцэтгэл, гарч буй ахиц дэвшлийг үнэлэхийн тулд Усны менежментийн протокол нь нийт 4 үзүүлэлтэд хамаарах шалгууруудыг тодорхойлсон:

1. Усны засаглал
2. Ус ашиглалтын менежмент
3. Усны сав газрыг хамарсан төлөвлөлт
4. Усны тайлагнал болон гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ 1: УСНЫ ЗАСАГЛАЛ

Зорилго

Усны менежментийн хүрээнд амлалт, үүрэг хариуцлагыг тодорхойлж түүнийг оролцогч талуудын бүлэгт мэдээлэн харилцдаг эсэхийг баталгаажуулах..

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	- Усны менежментийн чиглэлээр тодорхойлсон үүрэг амлалт, явц тодорхой байх боловч тус үүрэг амлалтууд нь ТУУТ стандартын усны менежментийн хүрээний зорилготой нийцэхгүй байж болно. - Усны менежментийн чиглэлийн үүрэг, хариуцлагыг холбогдох ажилтнуудад хуваарилсан боловч , тэдний үүрэг хариуцлага тодорхойлогдоогүй байж болно. - Ус ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн шаардлагууд, тодорхойлон гаргасан үүрэг амлалтуудыг даган мөрдөж буй эсэхийг хянан шалгах үйл явцыг тогтсон байх.
А	- Удирдах албан тушаалтнаар баталгаажсан усны менежментийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь ТУУТ стандартын Усны менежментийн хүрээний зорилгод нийцсэн байх. - Усны менежментийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох ажилтнууд, туслан гүйцэтгэгчид болон уурхайн түвшний ус ашиглалттай холбоотой оролцогч талуудад танилцуулж, мэдэгдсэн байх. - Усны сав газрын болон ус ашиглалтын менежментийн төлөвлөлтөд хамаарах чиг үүрэг, хариуцлага, эргэн тайлагнах үүргийг тодорхойлсон байх.

АА	1. Устай холбоотой эрсдэл, боломжуудын үнэлгээг жил тутмын үйл ажиллагааны болон төсвийн төлөвлөлтөд тусгасан байх. 2. Дотоод аудит нь дараах зүйлсийг тодорхойлох зорилгоор хийгдсэн байх: a. Уурхайн усны менежментийн хэрэгжилт нь ТУУТ стандартын Усны менежментийн хүрээний зорилгод тусгасантай нийцэж байгааг тодорхойлох b. Усны менежментийн чиглэлээр тодорхойлсон үүрэг амлалтыг холбогдох ажилтнууд, туслан гүйцэтгэгчид болон уурхайн түвшний ус ашиглалттай холбоотой оролцогч талуудад танилцуулж, мэдэгдсэн байх, c. Ус ашиглалтын менежмент болон усны сав газрын төлөвлөлтөд хамаарах чиг үүрэг, хариуцлага, эргэн тайлагнах үүргийг тодорхойлсон эсэх.
ААА	1. Хөндлөнгийн аудит нь дараах зүйлсийг тодорхойлох зорилгоор хийгдсэн байх: a. Уурхайн усны менежментийн хэрэгжилт нь ТУУТ стандартын Усны менежментийн хүрээний зорилгод тусгасантай нийцэж байгааг тодорхойлох b. Усны менежментийн чиглэлээрх тодорхойлсон үүрэг амлалтыг холбогдох ажилтнууд, туслан гүйцэтгэгчид болон уурхайн түвшний ус ашиглалттай холбоотой оролцогч талуудын бүлэгт мэдээлсэн эсэх.
	c. Ус ашиглалтын менежмент болон Усны сав газрын төлөвлөлтөд хамаарах чиг үүрэг, хариуцлага, эргэн тайлагнах үүргийг тодорхойлсон эсэх.

Түгээмэл асуултууд: Усны засаглал

#	Түгээмэл асуултууд
1	Усны менежментийг (water stewardship) юу гэж тодорхойлдог вэ?
2	Холбогдох ажилтнууд, туслан гүйцэтгэгчид, уурхайн түвшний оролцогч талуудын бүлэгт хэн багтах вэ?
3	Нэг усны сав газарт олон тооны уурхай үйл ажиллагаа явуулж буй бол бүсийн хэмжээний усан хагалбарын хамгааллын арга хандлагыг хэрхэн тусгах вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 2: УС АШИГЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

Зорилго

Уурхайн түвшинд ус ашиглалтын төлөвлөгөө, менежментийн тогтолцоо хэрэгжиж буйг баталгаажуулах. Энэхүү үзүүлэлтэд усны чанар болон хэмжээг хамааруулсан.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	1. Гадаргын болон гүний устай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх. 2. Уурхайн ус ашиглалтын гүйцэтгэлд мониторинг хийх үйл явц бүрдэж бий болсон байх. 3. Уурхайн түвшинд усны чанар болон тоо хэмжээний өгөгдлийн бүртгэлийг хөтөлсөн байх.
А	1. Ус ашиглалтын менежментийг системтэйгээр хэрэгжүүлэх аргачлалыг бий болгож, хэрэгжүүлсэн байх, үүнд дараах зүйлс багтсан байх: а. Уурхайн хэмжээнд усны балансын тооцооллыг боловсруулсан байх. Усны балансыг урьдчилан тогтоосон давтамжтайгаар шинэчилж, мониторингийн өгөгдлүүдэд тусгаж байх. б. Гадаргын болон гүний усны чанар, тоон үзүүлэлтүүдийг хамруулж, тодорхойлсон эрсдэлд чиглэсэн арга хэмжээг тусгасан мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байх. с. Тодорхойлон гаргасан эрсдэлүүд дээр суурилсан хяналтын үйл явц бүрэлдэн бий болж, хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг байх. д. Ус ашиглалттай холбоотой гарч болзошгүй эрсдэл, ослын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан байх. е. Холбогдох ажилтнууд болон туслан гүйцэтгэгчид нарт тэдний хамаарах үүрэг, хариуцлагын дагуу сургалтад хамруулсан байх.

АА	1. Усны балансын тооцооллыг урьдчилан тогтоосон давтамжтайгаар шинэчлэхдээ үйл ажиллагааны явцад цаг уур, орчны олон нөхцөлүүдийн боломжит нөлөөллийг мониторингийн өгөгдөлд харгалзан үздэг байх. 2. Ус ашиглалтын гүйцэтгэлийг сайжруулах боломжуудыг тодорхойлох үйл явц тогтсон байх, төлөвлөсний дагуу үүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр дүнтэй байдалд нь хяналт тавьдаг байх. 3. Устай холбоотой эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, бууруулах, арилгах үр дүнтэй арга хэмжээг авч , үр дүнтэй байдалд хяналт тавьдаг байх. 4. Хяналтын өгөгдлийг нэгдсэн системд хадгалж, тогтмол хугацаанд дүн шинжилгээг хийн байнгын сайжруулалт хийх болон шийдвэр гаргах аливаа үйл явцад удирдлагын багийг мэдээллээр хангадаг байх. 5. Тодорхойлон гаргасан эрсдэлийн мэдээлэлд үндэслэн гүний усны моделийг цар хүрээний хувьд зохих түвшинд нарийвчлалтайгаар гаргадаг байх. 6. Ус ашиглалтын менежмент нь А түвшинд тавигдах шаардлагуудыг хангасан эсэхийг тодорхойлох дотоод аудит хийгдсэн байх.
ААА	1. Одоо хэрэгжүүлж буй усны менежментийн шийдвэр гаргах үйл явц болон хаалтын төлөвлөгөөнд цаашид урт хугацаанд анхаарах усны менежментийн асуудлуудыг тусгасан байх. 2. Уурхайн үйл ажиллагаа хаагдсаны дараа тухай бүс нутгийн урт хугацааны усны менежментийн боломжуудыг тодорхойлж түүнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг үйл ажиллагаа явцад хуримтлуулах эсвэл хаалтын төлөвлөгөөнд тусгахад анхаарах шаардлагатай. 3. Ус ашиглалтын менежментийн хэрэгжилт нь А болон АА түвшний шаардлагуудад нийцэж буй эсэхийг тогтоох хөндлөнгийн аудит хийгдсэн байх. 4. Үр дүнтэй байдлын үнэлгээ хийгдэж, цаашид сайжруулж болох боломжуудыг тодорхойлж хэрэгжилтийг хянах үйл явц бүрдсэн байх.

Түгээмэл асуултууд: Үйл ажиллагааны усны менежмент

#	Түгээмэл асуултууд
4	“Усны ашиглалтын гүйцэтгэлийн тайлан гэж юуг ойлгох вэ?
5	Олон нийтэд тайлагнаж буй усны үзүүлэлтийн талаарх хараат бус баталгаажуулалт гэж юу болох, үүнийг Үзүүлэлт 2, ААА түвшинд шаардагдах хөндлөнгийн аудитад багтаан оруулж болох уу?
6	“Уурхайн хэмжээний усны баланс” гэж юу вэ?
7	“Хяналтын шинжилгээний үр дүнд тогтмол хугацаанд дүн шинжилгээг хийж сөрөг нөлөөллийг бууруулах, үйл ажиллагаанд тогтмол сайжруулалт хийхэд болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтныг мэдээллээр тогтмол хангадаг байх гэдгийг хэрхэн ойлгох вэ?
8	“Тодорхойлон гаргасан эрсдэлийн мэдээлэлд үндэслэн усны загварыг хангалттай хэмжээнд дэлгэрэнгүйгээр, цар хүрээний хувьд зохистой түвшинд нарийвчлалтайгаар боловсруулах” гэдгийг хэрхэн ойлгох вэ?
9	Үнэлэн гаргасан эрсдэлүүдийг бууруулахын тулд тодорхойлон гаргасан төлөвлөгөө нь нь урьдчилсан сэргийлэх зорилгоор тодорхойлсон боломжуудтай ижил төстэй юу?
10	Усны менежментийн хүрээнд “урт хугацааны” гэсэн үг ямар утгатай вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 3: УСНЫ САВ ГАЗРЫГ ХАМАРСАН ТӨЛӨВЛӨЛТ

Зорилго

Усны сав газрын төлөвлөлт болон засаглалд уурхайн зүгээс бусад ус ашиглагч талууд болон Оролцогч талуудын бүлгүүдийн оролцоог дэмжин хамтран ажилладаг болохыг баталгаажуулах. Энэхүү үзүүлэлт нь уурхайн үйл ажиллагааны хамрах хүрээнээс илүү усны сав газрын түвшний төлөвлөлтөд төвлөрдөг.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	- Уурхай нь өөрт хамаарах усны сав газрын хил хязгаарыг тодорхойлсон байх. - Устай хамаарах оролцогч талуудын бүлгийг тодорхойлсон байх. - Усны сав газрын төлөвлөлт дэх оролцооны үүрэг хариуцлагыг тодорхойлсон байх.
А	- Усны сав газрын хэмжээнд оролцогч талуудын бүлгүүдийн усны нөөцийн ашиглалт,болон тэдгээрийн устай холбоотой орон нутгийн практик, итгэл үнэмшил, заншил, уламжлалт мэдлэгийг судлах замаар илүү сайн мэдээлэл, ойлголт авахын тулд хамтын оролцоотой үйл ажиллагааг нэвтрүүлсэн байх. - Уурхайн нь шууд эсвэл шууд бусаар усны сав газрын засаглалд оролцдог байх. - Ус ашиглалтын менежментийн практик нь усны сав газарт үзүүлж буй хуримтлагдах нөлөөлөлд хэрхэн нөлөөлж буйд үнэлгээ хийдэг байх.
АА	- Холбогдох Оролцогч талуудын бүлгийн оролцоотойгоор усны сав газрын эрсдэл болон боломжуудыг тодорхойлж, эрэмбэлсэн байх. - Уурхайн ус ашиглалтын менежментийн практик нь онцгой өндөр эрсдэлийг хэрхэн шийдэж буй талаарх ойлголт, мэдээллийг холбогдох оролцогч талуудын бүлэгт мэдээлдэг, мэдээлэл харилцааны тогтолцоог нэвтрүүлсэн байх, - Уурхайн хяналтаас гадуурх, өндөр эрсдлүүдийн хувьд уурхай нь усны сав газрын засаглалд оролцож, хамтын хариу арга хэмжээний боломжуудыг үнэлэн, боловсруулахад оролцдог байх.

AAA	1. А болон АА түвшний оролцооны үйл ажиллагааны үндсэн дээр тухайн уурхайн усны сав газарт доор дурдсаны аль нэг санаачилга хэрэгжиж байх: a. Усны сав газрын ашиглалтын зорилтыг тодорхойлох, үүнд газар ашиглалтын төлөвлөгөөнд багтсан зүйлс орсон байх. b. Усны сав газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулах. c. Усны сав газрын төлөвлөгөө болон устай хамаарах оролцогч талуудын бүлгүүдийн бодит оролцоонд эргэн хяналт хийдэг байх. d. Усны сав газрын хэмжээнд хийгдэх хамтарсан мониторинг
-----	---

Түгээмэл асуултууд: Усны сав газрыг хамарсан төлөвлөлт

#	Түгээмэл асуултууд
11	“Усны сав” газар гэж юуг хэлэх вэ?
12	Ус сав газрын арга хэмжээний төлөвлөлт нь ямар зорилготой вэ?
13	Өөр бусад ямар нэгэн ус хэрэглэгч байхгүй алслагдсан газар дахь усны сав газарт үйл ажиллагаа явуулж буй уурхай нь Үзүүлэлт 3, Түвшин ААА дээр тогтоосон хамтарсан санаачилгуудын төрлийг хэрхэн дэмжиж болох вэ?
14	Усны сав газрын мониторинг гэдэг юу багтах вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 4: УС АШИГЛАЛТЫН ТАЙЛАГНАЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ

Зорилго

Гүйцэтгэлээ үнэлэх зорилгоор устай хамаарах зорилт, хүрэх түвшнүүдийг тодорхойлсон эсэх болон шийдвэр гаргалт болон олон нийтэд нээлттэй мэдээлэхэд зориулсан тайлагнал хийгддэг эсэхийг баталгаажуулах.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	1. Хамаарах устай холбоотой эрсдэл болон/эсвэл боломжууд дээр усны гүйцэтгэлийн зорилт(ууд) эсвэл хүрэх түвшнийг гаргасан байх.
А	1. Зорилт(ууд) эсвэл хүрэх түвшнийг хангах чиглэлд гарч буй үйл ажиллагааны сайжруулалтыг тогтмол хянаж, уурхайн түвшний удирдах албан тушаалтанд тайлагнадаг байх. 2. Усны чиглэлээр олон нийтэд нээлттэй тайланд тодорхойлсон зорилт эсвэл хүрэх түвшинд хамаарах гүйцэтгэлийг багтаадаг байх.
АА	1. Тайлант жилд устай холбоотой зорилт, хүрэх түвшин нь биелэгдсэн эсвэл засан залруулах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжүүлж байх. 2. Усны чиглэлээр олон нийтэд хандсан тайлагналын үнэн зөв байдлыг хараат бусаар баталгаажуулах тогтолцоог бүрдүүлсэн байх.
ААА	1. Ус ашиглалтын тайлан дээр оролцогч талуудын саналыг идэвхтэйгээр авдаг байх. 2. Олон нийтэд хандсан тайлагналын хараат бус баталгаажуулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй болгодог байх. 3. Олон нийтэд хандсан тайлагналд уурхайн түвшний усны талаарх өгөгдөл багтдаг байх.

Түгээмэл асуултууд: Усны тайлагнал болон гүйцэтгэл

#	Түгээмэл асуултууд
15	Зорилт болон хүрэх түвшин хоёр ямар ялгаатай вэ?

ХАВСРАЛТ 1: ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

1. Ус хамгааллыг (water stewardship) юу гэж тодорхойлдог вэ?

Усны менежмент хэмээх үгэнд тохирсон нийтлэг тодорхойлолт байхгүй тул компани бүр үүнийг өөрийн нөхцөл байдал, уурхайн усны сав газрын нөхцөл зэрэгт нийцүүлэн тодорхойлох шаардлагатай. Жишээ болох хоёр тодорхойлолтыг доор харуулав:

Усны менежмент гэж “уурхай, сав газрын хэмжээнд холбогдох оролцогч талуудыг хамруулсан нийгмийн хувьд тэгш, хүртээмжтэй, байгаль орчны хувьд ээлтэй, эдийн засгийн хувьд үр өгөөж бүхий байдлаар ус ашиглахыг” хэлнэ – Усны менежментийн эвсэл (Alliance for Water Stewardship) (Мөн Олон улсын уул уурхай, металлын зөвлөлөөс хүлээн зөвшөөрсөн- ICMM) <http://a4ws.org/about/impacts-of-aws/>

“Усны менежмент нь аливаа бизнес, үйл ажиллагаа нь усны хомсдол, бохирдлоос үүдэн гарах эрсдэлээ ойлгон, усыг тогтвортойгоор нийтийн хамтын нөөц байдлаар удирдахад туслах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх явдал юм”. – Даян дэлхийн байгаль хамгаалах сан - World Wildlife Fund http://wwf.panda.org/our_work/water/water_management/

2. Хамаарах ажилтнууд, туслан гүйцэтгэгчид, уурхайн түвшний оролцогч талуудын бүлэгт хэн багтах вэ?

Холбогдох ажилтнууд болон туслан гүйцэтгэгчид гэж усны менежментэд хамаарах шууд болон шууд бус үүрэг хариуцлага хүлээсэн талуудыг хэлнэ. Шууд үүрэг бүхий талын жишээнд ус цэвэршүүлэх ажил хариуцсан менежер, ус цэвэршүүлэх байгууламжийн оператор эсвэл байгаль орчны мониторингийн чиг үүрэг бүхий талууд багтаж болно. Шууд бус үүрэг бүхий талын жишээнд ханган нийлүүлэлтийн ажилтнууд багтаж болох ба тэд усны менежмент, цэвэрлэгээний байгууламжийн дэд бүтцийн чухал хэсэг болох хяналтын тоног төхөөрөмж, шугам хоолой зэргийг захиалан нийлүүлдэг ба харин усны менежментийн үйл ажиллагаанд шууд оролцдоггүй.

Уурхайн түвшний холбогдох оролцогч талуудын бүлгийн жишээнд усны сав газар дахь усны асуудлаар ашиг сонирхол бүхий ус ашиглагчид болон ус ашиглах эрх эзэмшигчид багтана.

3. Нэг усны сав газарт олон тооны уурхай үйл ажиллагаа явуулж буй бол усны сав газрын бүсийн хэмжээний хамгааллын менежментийг хэрхэн тусгах вэ?

Компани нэг усны сав газарт хэд хэдэн тооны уурхай ажиллуулдаг бол компани нь усны менежментийн чиглэлээр бүсийн менежментийг хэрэгжүүлж болно. Үүний хүрээнд мөн бусад компаниудтай хамтран ажиллах үйл явц багтаж болно. Энэ тохиолдолд уурхайн түвшний болон бүсийн түвшний ажилтнуудын чиг үүргийн хуваарилалт нь тодорхой, дэмжлэг үзүүлэх системийг хөгжүүлсэн, зохих түвшинд нь хэрэгжүүлдэг байх ёстой. Усны менежментийн зорилт, хүрэх түвшнийг уурхайн бус харин бүсийн хэмжээнд тогтоож, олон нийтэд мэдээлэхдээ бүсийн нэгдсэн дүнгээр тайлагнах боломжтой.

4. “Ус ашиглалтын гүйцэтгэл” гэж ямар утгатай вэ?

Ус ашиглалтын гүйцэтгэлийг устай хамаарах эрсдэлд үндэслэн уурхайн түвшинд шийдэх ба үүнд усны чанар болон тоо хэмжээний асуудлыг багтаан авч үзнэ.

5. Ус ашиглалтын гүйцэтгэлийн олон нийтэд хандсан тайлагналын хараат бус баталгаажуулалт гэж юу болох, үүнийг Үзүүлэлт 2, ААА түвшинд шаардагдах хөндлөнгийн аудитад багтаан оруулж болох уу?

Баталгаажуулалтын хамрах хүрээ нь ус ашиглалтын гүйцэтгэлийн өгөгдөл, мэдээллийн үнэн бодит байдал, иж бүрэн байдал болохыг ашиглагдах боломж, үүнд тодорхойлон гаргасан зорилт болон/эсвэл хүрэх түвшнийг хангах чиглэлээр хийгдсэн гүйцэтгэл зэргийг хамарна. Баталгаажуулалт нь үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлсныг харгалзан үзэхээс гадна тухайн үзүүлэлтүүдийг тогтсон хугацаанд тодорхойлж, тайлагнаж ирсэн менежментийн болон тайлагналын системийг мөн харгалздаг. Хэрэв аудитын хамрах хүрээ нь ус ашиглалтын гүйцэтгэлийн өгөгдлийн үнэн бодит байдал, ашиглагдах байдал, иж бүрэн байдлыг хамарч буй бол энэхүү шаардлагыг Үзүүлэлт 2, ААА түвшин дээр шаардагддаг хөндлөнгийн аудит дээр мөн харгалзана.

6. “Уурхайн хэмжээний усны баланс” гэж юу вэ?

Уурхайн хэмжээний усны баланс нь уурхайн ашиглалтын хугацаа, хаалтын үеийг хамруулан ашиглах орц, гарц болон нөөцийн хэмжээ, усны менежментийн дэд бүтцийг урьдчилан тооцон гаргадаг загварчлал юм. Усны баланс нь төрөл бүрийн таамаг загварчлалд тусгах боломжийг олгодог. Үүнд гидрологийн “хэвийн” нөхцөл, гидрологийн ус ихтэй болон хуурай нөхцөл, боломжит ашиглалтын нөхцөл, хадгалах хүчин чадлын хязгаарлалт, уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарах нөлөөлөл (жишээ нь усны хэрэглээ, хаягдлын хязгаарлалт, ган) зэргийг тооцдог. Загварчлалд багтсан гидрологийн ус ихтэй болон хуурай нөхцөлийн цар хүрээг эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр тодорхойлно. Усны балансыг мөн урт хугацаанд усны чанарыг урьдчилан тооцох моделийн үндэс болгон ашиглаж болно.

Уурхайн хэмжээний усны балансыг усны менежментийн дэд бүтцийн төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх, байгаль орчин, тухайн усны сав газар дахь бусад ус ашиглагчдад богино болон урт хугацаанд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор ашигладаг.

7. Хяналтын өгөгдлийг хадгалж тогтмол хугацаанд дүн шинжилгээг хийж байнгын сайжруулалт болон/шийдвэр гаргах үйл явцыг мэдээллээр хангадаг байх” гэдгийг хэрхэн ойлгох вэ?

Усны чанар болон хэмжээтэй холбоотой өгөгдлийг тусгайлан өгөгдлийн санд хадгалж хувьсагчууд (байгаль орчны болон үйл ажиллагааны өгөгдлийг багтааж болно) дээр дүн шинжилгээ хийдэг. Өгөгдлийн сан нь тусгайлсан байгаль орчны менежментийн эсвэл ерөнхий эсвэл хүснэгт

ашигласан программ хэлбэртэй байж болно. Ямар хэлбэртэй байх, ямар төрлийн өгөгдлийн сан хэрэгцээнд нь хамгийн сайн тохирохыг уурхайн усны менежмент хариуцсан ажилтан өөрийн үзэмжээр шийдэж болно. Үүний нэгэн адил уурхайн усны асуудал хариуцсан менежер нь усны менежменттэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад нь мэдээлэл өгөхийн тулд ямар төрлийн дүн шинжилгээ шаардлагатайг тодорхойлон гаргана. Өгөгдөл болон дүн шинжилгээг шийдвэр гаргалтад ашиглахын тулд тухайн уурхайн устай холбоотой шийдвэр гаргах түвшний ажилтан нь тухайн мэдээллийг харгалзан тусгаж буйг илтгэн харуулах шаардлагатай.

8. Тодорхойлон гаргасан эрсдэлийн мэдээлэлд үндэслэн гүний усны загварыг хангалттай хэмжээнд дэлгэрэнгүйгээр, цар хүрээний хувьд зохистой түвшинд нарийвчлалтайгаар боловсруулах” гэдгийг хэрхэн ойлгох вэ?

Энэ нь тухайн уурхай нь ус татан ашиглалт, нэвчилт эсвэл шүүрэлт зэрэг асуудлаас үүдэн уурхайн ашигласан ус гүний усны системд орох боломжит эрсдэлийг анхаарч, тухайн боломжит эрсдэл болон үүнийг бууруулах боломжуудыг үнэлэхүйц хэмжээ, түвшинд үзэл баримтлалын болон/эсвэл тоон моделийг боловсруулан ашиглах гэсэн утгыг агуулна.

9. Үнэлэн гаргасан эрсдэлүүдийг бууруулахын тулд тодорхойлон гаргасан боломжууд нь урьдчилсан сэргийлэх зорилгоор тодорхойлсон боломжуудтай ижил төстэй юу?

Зарим компаниуд дээр тодорхойлон гаргасан эрсдэлүүдэд боломжуудыг агуулж байдаг. Тиймээс компани нь эрсдэлийг бууруулах арга хэмжээг болон боломжуудын (сайжруулалт) амжилттай хэрэгжүүлж буй бол эдгээр нь АА түвшинд үнэлэгдэнэ. Гэвч зөвхөн эрсдэлийг (жишээ нь тулгарч буй аюул) анхаарч буй бол компани нь А түвшинд үнэлэгдэнэ.

10. Усны менежментийн хүрээнд урт хугацааны гэсэн үг ямар утгатай вэ?

Урт хугацааны усны менежмент нь уурхайн үйл ажиллагаа явуулах нийт хугацаанаас илүү урт хугацааг хамаарах бөгөөд үүнийг уурхайн хаалтын төлөвлөгөөтэй уялдуулан хийнэ. Уурхай үйл ажиллагаа явуулах шатанд хаалтын үеийн үүрэг хариуцлага, урт хугацааны ус цэвэршүүлэх зардлыг бууруулах боломжуудыг эрэлхийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжийг нэмэгдүүлэх зэргийг анхаарна.

11. “Усны сав” газар гэж юуг хэлэх вэ?

Усны сав газар гэдэг нь бүх гадаргын урсац болон газрын доорх ус нэг голын адаг, голын цутгал, эсвэл эх газар, тэнгист цутгах цэг хүртэл урсах нутаг дэвсгэрийг хэлнэ. Мөн энэ нь тухайн уурхайн ашигласан усны гаргалтаас доош урсгалын хэсэгт нөлөөлдөг бүсийг хамардаг. Энд дурдсан усны сав газарт холбогдох газрын доорх усны бүсүүд болон гадаргын усны (нуур, гол гэх мэт) тодорхой хэсгүүд орж болно. Усны сав газрыг ус хураах талбай, сав газар (эсвэл дэд сав газар) гэж ч нэрлэдэг. Олон Улсын Уул Уурхайн Зөвлөл (ICMM) “ус хураах талбай” гэсэн нэр томъёог ашигладаг

бол ТУУТ” стандартат “усны сав газар” гэж нэрлэдэг бөгөөд эдгээр нэр томьёо нь хоорондоо ижил утгатай юм.

Энэ талаарх дэлгэрэнгүй зааварчилгааг Олон улсын уул уурхай, металлын зөвлөл болон Усны менежментийн эвслийн Уул уурхай металлын салбарын ус цуглуулах талбайд суурилсан усны менежментийн практик хөтөч (ICMM and Alliance for Water Stewardship - A Practical Guide to Catchment-Based Water Management for the Mining and Metals Industry (2015)) хэмээх баримт бичиг дээрээс үзэж болно.

12. Усны сав газрын хэмжээний төлөвлөлт нь ямар зорилготой вэ?

Олон улсын уул уурхай, металлын зөвлөлөөс (ICMM) өөрийн гаргасан Уул уурхай, металлын салбарт зориулсан Ус цуглуулах талбайд суурилсан усны менежментийн практик хөтөч (Practical Guide to Catchment- Based Water Management) дээр дэлгэрэнгүй мэдээлэл тусгасан. Энэхүү баримт бичигт дараах тодорхойлолтыг заасан:

Усны сав газрын хэмжээн дэх усны нөөцийн менежмент нь аливаа хамаарал бүхий асуудал, үйл ажиллагааг тус тусад нь авч үзэхийн оронд бүхэл бүтэн системийн хэмжээнд харгалзан үзэхийг зорьдог. Үүнд усны хангамж, чанарт нөлөөлдөг ус зүйн нөхцөл, газрын ашиглалт төдийгүй улс төр, эдийн засаг, нийгэм, экологийн өргөн хүрээний хүчин зүйлийг авч үзэх шаардлагатай болдог. Усны сав газрын хэмжээнд суурилсан энэ менежмент нь усны нөөцөд олон талын ашиг сонирхол (ахуйн хэрэглэгчид, аж үйлдвэр, зохицуулагч байгууллагууд, улс төрчид гэх мэт)-ын өрсөлдөөнөөс үүсэх дарамт, зөрчилдөөнийг хэрхэн зөв зохицуулж болохыг цогцоор нь ойлгохыг байгууллагуудад уриалдаг.

Мөн энэхандлагань өөр өөр салбарын оролцогчдыг нэгтгэн, тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хамтран шийдвэрлэх, эцэст нь эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн түншлэл байгуулахыг шаарддаг.

13. Өөр бусад ямар нэгэн ус хэрэглэгч байхгүй алслагдсан газар дахь усны сав газарт үйл ажиллагаа явуулж буй уурхай нь Үзүүлэлт 3, Түвшин ААА дээр тогтоосон хамтарсан санаачилгуудын төрлийг хэрхэн дэмжиж болох вэ?

Алслагдсан газарт үйл ажиллагаа явуулж буй уурхай нь тухайн усны сав газарт өөр ус ашиглагч байхгүй тохиолдолд өөрийн үйл ажиллагааны усны менежмент, зорилгодоо сав газрын талаарх ойлголт мэдээллийг тусгасан болохоо илтгэн харуулснаар ААА түвшнийг хангасанд тооцогдож болно.

14. Усны сав газрын мониторинг гэдэгт юу багтах вэ?

Усны сав газрын хэмжээний мониторингийг холбогдох оролцогч талуудын бүлэг болон бусад ус хэрэглэгчдийн оролцоотойгоор тодорхойлон гаргасан сав газар үзүүлэлт нэг бүр дээр үндэслэн тодорхойлно. Үүнд олон тооны ус хэрэглэгч буй бол хуримтлагдах нөлөөллийн мониторинг, дотоод

урсцын шаардлагуудын мониторинг, хамтарсан мониторингийн хөтөлбөр зэргийг багтааж болно.

15. Зорилт болон хүрэх түвшин хоёр ямар ялгаатай вэ?

Энэхүү протоколын хувьд зорилт гэж чанарын шинжтэй зорилтуудыг илэрхийлэх бол хүрэх түвшин гэж тоон шинжтэй зорилтыг илэрхийлнэ.

16. Хэрэгцээт лавлах баримт бичгүүд

1. Олон улсын уул уурхай, металлын зөвлөл (ICMM): Ус цуглуулах талбайд суурилсан усны менежментийн практик хөтөч (Practical Guide to Catchment- Based Water Management) <https://www.icmm.com/guide-to-catchment-based-water-management>
2. Олон улсын уул уурхай, металлын зөвлөл: Усны зохист тайлагналын практик хөтөч (A Practical Guide to Consistent Water Reporting) <https://www.icmm.com/en-gb/environment/water/water-reporting>

ХАВСРАЛТ 2: ТУУ (TSM) СТАНДАРТЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАХ ХУУДАС

Усны менежмент

Уурхайн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн:		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг/ Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Албан тушаал	Албан тушаал	Албан тушаал	Албан тушаал

	АСУУЛТ	T	Y	NA	Тайлбар болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 1: УСНЫ ЗАСАГЛАЛ					
Үзүүлэлт 1 Түвшин B	1. I Усны менежментийн чиглэлээрх тодорхойлсон үүрэг амлалт, хүчин чармайлт нь тодорхой байна уу?. Үүрэг амлалтууд нь ТУУТ (TSM) стандартын хүрээллийн зорилготой нийцсэн үү?				
	2. Усны менежментийн чиглэлээрх үүрэг, эргэн тайлагналыг хамаарах ажилтнуудад хуваарилан оногдуулсан, тэдний үүрэг хариуцлагыг тодорхойлсон байна уу?				

Үзүүлэлт 1 Түвшин В	3. Устай хамаарах хууль тогтоомжийн шаардлагууд, тодорхойлон гаргасан үүрэг амлалтуудыг даган мөрдөөгүй буйг хянан шалгах үйл явц тогтсон уу?				
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 1 Түвшин А	1. Ахлах удирдлагын зүгээс илэрхийлсэн усны менежментийн чиглэлээрх үүрэг амлалт нь ТУУТ (TSM) Усны менежментийн хүрээллийн зорилтод нийцсэн үү?				
	2. Усны менежментийн чиглэлээрх тодорхойлсон үүрэг амлалтыг хамаарах ажилтнууд, туслан гүйцэтгэгчид болон уурхайн түвшний усны хамааралтай оролцогч талуудын бүлэгт мэдээлдэг үү?				
	3. Үйл ажиллагаанд шаардагдах усны менежмент болон усны сав газрын хэмжээний төлөвлөлтөд хамаарах чиг үүрэг, хариуцлага, эргэн тайлагнах үүргийг тодорхойлсон уу?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 1 Түвшин АА	1. Устай холбоотой эрсдэл, боломжуудын үнэлгээг жил тутмын бизнес төлөвлөлт болон/эсвэл төсвийн үйл явцтай уялдуулдаг уу?				
	2. Доорх зүйлсийг тогтоох дотоод аудит хийгдсэн үү:				
	a. Уурхайн усны менежментийн арга ажиллагаа нь ТУУТ (TSM) стандартын Усны менежментийн хүрээллийн зорилттойнийцэж буй хэм хэмжээ?				
	b. Усны менежментийн чиглэлээрх тодорхойлсон үүрэг амлалтыг хамаарах ажилтнууд, туслан гүйцэтгэгчид болон уурхайн түвшний усны хамааралтай оролцогч талуудын бүлэгт мэдээлдэг үү?				

	АСУУЛТ	Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
	с. Ус ашиглалтын менежмент болон усны сав газрын хэмжээний төлөвлөлтөд хамаарах чиг үүрэг, хариуцлага, эргэн тайлагнах үүргийг тодорхойлсон байна уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 1 Түвшин ААА	1. Доорх зүйлсийг тогтоох хөндлөнгийн аудит хийгдсэн үү:				
	a. Уурхайн усны менежментийн арга ажиллагаа нь ТУУТ (TSM) стандартын Усны менежментийн хүрээллийн зорилттой нийцэж буй хэм хэмжээ?				
	b. Усны менежментийн чиглэлээрх тодорхойлсон үүрэг амлалтыг хамаарах ажилтнууд, туслан гүйцэтгэгчид болон уурхайн түвшний усны хамааралтай оролцогч талуудын бүлэгт мэдээлсэн эсэх?				
	c. Үйл ажиллагаанд шаардагдах усны менежмент болон хагалбар газрын хэмжээний төлөвлөлтөд хамаарах чиг үүрэг, хариуцлага, эргэн тайлагнах үүргийг тодорхойлсон эсэх?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
	ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Түвшин: _____			

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 2: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УСНЫ МЕНЕЖМЕНТ					
Үзүүлэлт 2 Түвшин В	1. Гадаргын болон гүний устай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх зүйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн үү?				
	2. Уурхайн ус ашиглалтын гүйцэтгэлд мониторинг хийх үйл явц бүрдэж бий болсон уу?				
	3. Уурхайн түвшний усны чанар болон тоо хэмжээний өгөгдлийн бүртгэлийн бүрдүүлсэн үү?				
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 2 Түвшин А	1. Ус ашиглалтын менежментийн чиглэлээрх системийн арга хандлагыг бүрдүүлэн, хэрэгжүүлж байх, үүнд дараах багтсан уу?				
	а. Уурхайн хэрэгцээнд усны балансыг бэлтгэн гаргасан байх. Усны балансыг урьдчилсан тогтоосон давтамжтайгаар шинэчилж, мониторингийн өгөгдлийг үүнд тусгаж байна уу?				
	б. Гадаргын болон гүний усны чиглэлээрх усны мониторингийн хөтөлбөрт усны чанар болон тоо хэмжээний параметруудийг багтаан хэрэгжүүлж, тодорхойлон гаргасан эрсдэлүүд дээр арга хэмжээ хэрэгжүүлдэг үү?				
	с. Тодорхойлон гаргасан эрсдэлүүд дээр суурилсан хяналтын явц бүрдэн бий болж, төлөвлөсний дагуу хэрэгждэг үү?				
	д. Устай хамаарах эрсдэл, тохиолдол дээр хариу арга хэмжээний болон магадалшгүй нөхцөлийн төлөвлөгөөг гаргасан уу?				
	е. Хамаарах ажилтнууд болон туслан гүйцэтгэгч нарыг тэдний хамаарах ажил үүргийн хуваарын дагуу сургалтад хамруулсан байх?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				

	АСУУЛТ	Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
Үзүүлэлт 2 Түвшин АА	1. Усны балансыг урьдчилан тогтоосон давтамжтайгаар шинэчилж, мониторингийн мэдээлэл болон уур амьсгалын олон төрөл нөхцөл байдлыг, үүнд уур амьсгалын өөрчлөлтийн боломжит хувьсагчуудыг (хэрэв үйл ажиллагааны шатанд хамааралтай бол) харгалзан үздэг үү?				
	2. Ус ашиглалтын гүйцэтгэлийг сайжруулах боломжуудыг тодорхойлох үйл явц тогтсон байх, төлөвлөсний дагуу үүнийг хэрэгжүүлэн, үр дүнтэй байдалд нь мониторинг хийдэг эсэх?				
	3. Устай хамаарах эрсдэлийн хяналтын арга хэмжээ тогтож, үр дүнтэй байдалд нь мониторинг хийдэг үү?				
	4. Байнгын сайжруулалт болон/ эсвэл шийдвэр гаргах үйл явцыг мэдээллээр хангах зорилгоор усны мониторингийн өгөгдлийг хадгалж, урьдчилан тогтоосон давтамжтайгаар дүн шинжилгээг хийдэг үү.				
	5. Тодорхойлон гаргасан эрсдэлийн мэдээлэлд үндэслэн гүний усны моделийг цар хүрээний хувьд зохих түвшинд нарийвчлалтайгаар гаргадаг уу				
	6. Ус ашиглалтын менежмент нь А түвшинд тавигдах шаардлагуудыг хангасан эсэхийг тодорхойлох дотоод аудит хийгдсэн үү?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 2 Түвшин ААА	1. Урт хугацааны усны менежментийн асуудлуудыг хэрэгжүүлж буй усны менежментийн шийдвэр гаргах үйл явц болон хаалтын төлөвлөгөөнд уялдуулан харгалздаг уу?				
	2. Одоо хэрэгжүүлж буй усны менежментийн шийдвэр гаргах үйл явц болон хаалтын төлөвлөгөөнд цаашид урт хугацаанд анхаарах усны менежментийн асуудлуудыг харгалзан үздэг үү.				

	АСУУЛТ	Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
	3. Ус ашиглалтын менежмент нь А болон АА түвшний үйл явцын шаардлагуудыг хангаж буй эсэхийг тогтоох хөндлөнгийн аудит хийгдсэн үү?				
	4. Үр дүнтэй байдлын үнэлгээ хийгдэж, сайжруулж болох боломжуудын хэрэгжилтийг хянах үйл явц бүрдсэн үү?				
	<i>Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэлийг ААА түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.</i>				
	ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Түвшин: _____			

	АСУУЛТ	Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 3: УСАН ХАГАЛБАР ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ					
Үзүүлэлт 3 Түвшин В	1. Уурхай нь өөрт хамаарах усны сав газрын хил хязгаарыг тодорхойлсон уу?				
	2. Устай хамаарах оролцогч талуудын бүлгийг тодорхойлсон?				
	3. усны сав газрын хэмжээний төлөвлөлт дэх оролцооны үүрэг хариуцлагыг оногдуулсан уу?				
	<i>Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.</i>				

Үзүүлэлт 3 Түвшин А	1. Усны сав газрын хэмжээнд оролцогч талуудын бүлгүүдийн усны нөөцийн ашиглалт, болон тэдгээрийн устай холбоотой орон нутгийн практик, итгэл үнэмшил, заншил, уламжлалт мэдлэгийг судлах замаар илүү сайн мэдээлэл, ойлголт авахын тулд хамтын оролцооны үйл явцыг хэрэгжүүлдэг үү.				
	2. Уурхай нь шууд эсвэл шууд бусаар усны сав газрын засаглалд оролцдог уу?				
	3. Ус ашиглалтын менежментийн практик нь усны сав газарт үзүүлж буй хуримтлагдах нөлөөлөлд хэрхэн нөлөөлж буйд үнэлгээ хийдэг үү?				
<i>Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.</i>					
Үзүүлэлт 3 Түвшин АА	1. Хамаарах оролцогч талуудын бүлгийн оролцоотойгоор сав газрын эрсдэл болон боломжуудыг тодорхойлж, эрэмбэлсэн үү?				
	2. Уурхай нь хамаарах оролцогч талуудын бүлэгт өөрийн ус ашиглалтын менежментийн практик нь онцгой өндөр эрсдэлийг хэрхэн шийдэж буй талаарх ойлголт, мэдээллийг холбогдох оролцогч талуудын бүлэгт мэдээллэх мэдээлэл харилцааны үйл явцыг хэрэгжүүлдэг үү?				
	3. Уурхайн хяналтаас гадуурх, өндөр эрсдэлүүдийн хувьд уурхай нь усны сав газрын засаглалд оролцож, хамтын хариу арга хэмжээний боломжуудыг үнэлэн, боловсруулахад оролцдог уу?				

	АСУУЛТ	Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 Түвшин ААА	1. Усны сав газарт доор дурдсаны аль нэг санаачилга хэрэгжиж байх:				
	a. Усны сав газрын зорилтыг тодорхойлох, үүнд газар ашиглалтын төлөвлөгөөнд багтсан зүйлс орсон байх?				
	b. Усны сав газрын төлөвлөгөөг боловсруулах?				
	c. Усны сав газрын төлөвлөгөө болон устай хамаарах оролцогч талуудын бүлгүүдийн оролцоонд эргэн хяналт хийдэг?				
	d. Усны сав газрын хэмжээнд хийгдэх хамтарсан мониторинг?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэлийг ААА түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.				
	ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Түвшин: _____			

	АСУУЛТ	Т	Ү	NA	Тайлбар болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 4: УС АШИГЛАЛТЫН ТАЙЛАГНАЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ					
Үзүүлэлт 4 Түвшин В	1. Устай холбоотой эрсдэл болон/ эсвэл боломжууд дээр ус ашиглалтын гүйцэтгэлийн зорилт(ууд) эсвэл хүрэх түвшнийг гаргасан уу?				
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 4 Түвшин А	1. Зорилт(ууд) эсвэл хүрэх түвшнийг хангах чиглэлд гарч буй үйл ажиллагааны ахицыг байнга хянаж, уурхайн түвшний удирдах албан тушаалтанд тайлагнадаг уу?				
	2. Усны чиглэлээр олон нийтэд хандан тайлагнаж буй тайланд тодорхойлсон зорилт эсвэл хүрэх түвшинд хамаарах гүйцэтгэлийг багтаадаг?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 4 Түвшин АА	1. Тайлант жилд устай холбоотой зорилт эсвэл хүрэх түвшин нь биелэгдсэн эсвэл засан залруулах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжүүлж байна уу?				
	2. Усны чиглэлээр олон нийтэд хандсан тайлагналын үнэн зөв байдлыг хараат бусаар баталгаажуулах тогтолцоо эсвэл үйл явц бүрдсэн байна уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 4 Түвшин ААА	1. Ус ашиглалтын тайланд оролцогч талуудын бүлгийн саналыг идэвхтэйгээр авдаг?				
	2. Олон нийтэд хандсан тайлагналын хараат бус баталгаажуулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй болгодог уу?				
	3. Олон нийтэд хандсан тайлагналд уурхайн түвшний усны талаарх өгөгдөл багтдаг уу?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэлийг ААА түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.				
	ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 4 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Түвшин: _____			



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**

Усны менежментийн протокол

ТУУТ санаачилгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:

www.TSMInitiative.com

эсвэл

Канадын Уул Уурхайн Ассоциаци

www.mining.ca/tsm

Энэхүү нийтлэлийг боловсрол болон ашгийн бус бусад зорилгоор Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг зөвшөөрнө. Гэхдээ эх сурвалжийг бүрэн дурдсан байх шаардлагатай.

Энэхүү нийтлэлийг борлуулах болон бусад арилжааны зориулалтаар хуулбарлахыг Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хориглоно.

©2021 Канадын Уул Уурхайн Ассоциаци. Towards Sustainable Mining®, TSM®, зэрэг барааны тэмдгүүд нь Канад эсвэл бусад улс орнуудад Канадын Уул Уурхайн Ассоциацийн бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй барааны тэмдэг болно.



**МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ**



www.miningmongolia.mn



Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци



Mongolian National Mining Association



@miningmongolia



@mongolian_mining_association



Info@miningmongolia.mn



+976 7011 0163